



Маягт СЗХ04008

Даатгалын бүтээгдэхүүний мэдэгдлийн маягт

1	Мэдэгдэл огноо	Он	2021	Сар	03	Өдөр	31	
2	Мэдэгдэл гаргагчийн оноосон нэр	БОДЬ ДААТГАЛ ХК						
3	Даатгалын бүтээгдэхүүний нэр	ЭМЧ, ЭМЧИЛГЭЭНИЙ АЖИЛТНЫ ХАРИУЦЛАГЫН ДААТГАЛ						
4	Даатгалын бүтээгдэхүүний холбогдох даатгалын хэлбэр	Хариуцлагын даатгал						
5	Даатгалын бүтээгдэхүүнийг борлуулах тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр	Шийдвэрийн нэр			Огноо		Дугаар	
		Даатгалын бүтээгдэхүүнийг зах зээлд борлуулах тухай			2021.03.31		ТУЗ/2107	
6	Цахимаар борлуулах эсэх	<input checked="" type="checkbox"/> Тийм <input checked="" type="checkbox"/> Үгүй						
7	Даатгалын хураамжийг тооцоолсон актуарч:	Овог			Нэр			
		Балсан			Баярмагнай			
Мэдээллийн төрлийг сонгоно уу.								
8	<input checked="" type="checkbox"/> Даатгалын бүтээгдэхүүнийг шинээр борлуулах <input checked="" type="checkbox"/> Даатгалын бүтээгдэхүүнийг шинэчлэх							
Даатгалын бүтээгдэхүүний ерөнхий мэдээлэл								
9	Даатгалын зүйл	Хуулийн дагуу эмчлэх болон эмчилгээ сувилгаа хийх эрх бүхий эмч, сувилагч, бага эмч нар гуравдагч этгээдэд эмчилгээ сувилгааны үйлчилгээ үзүүлэх ажил үүргээ гүйцэтгэх явцын мэргэжлийн хариуцлага.						
	Даатгалын үндсэн эрсдэл	Хуулийн дагуу эмчлэх, эмчилгээний мэргэжлийн үйл ажиллагааны явуулах эрх бүхий даатгуулагч - эмч, сувилагч, бага эмч нар нь эмчлэх, эмчилгээ сувилгааны мэргэжлийн ажил үүргээ гүйцэтгэх явцдаа гуравдагч этгээдийн амь нас, эрүүл мэндэд хохирол учруулсаны улмаас хуулийн хариуцлага хүлээсэн тохиолдолд учирсан хохирол.						

Даатгалын нэмэлт эрсдэл	
Даатгалын хураамжийн хувь, хэмжээ	1.0 -6.0 хувь

ДААТГАЛД ХАМРАГДАХГҮЙ НӨХЦӨЛ

1. Мэргэжлээс шалтгаалаагүй аливаа үйл ажиллагаа;
2. Гэмт хэргийн шинжтэй үйлдэл;
3. Мэргэжлийн ёс зүйн зөрчил болон Монгол Улсын хуулиар зөвшөөрснөөс бусад нөхцөлд үйлчлүүлэгчийн хувийн нууцыг задруулснаас үүдэлтэй үйлчлүүлэгчийн нэр төр, сэтгэл санаанд учирсан хохирол;
4. Даатгуулагчийн өөрийн бие, сэтгэцийн өвчин эмгэг болон сэтгэл зүйн хямралаас шалтгаалсан;
5. Даатгуулагч нь эрх бүхий байгууллагын дүгнэлтгүйгээр даатгалын тохиолдол бий болсныг бүрэн болон хэсэгчлэн хүлээн зөвшөөрч, ямар нэгэн төлбөр урьдчилан барагдуулсан тохиолдолд;
6. Согтууруулах ундаа, мансууруулах эсвэл сэргээх үйлчилгээтэй бодис хэрэглэсэн, эм хэтрүүлэн хэрэглэсэн үедээ гаргасан шийдвэр, мөн үйлдлийн улмаас учруулсан хохирол;
7. Даатгагчийн өмгөөлөгчөөр үйлчлүүлэхээс татгалзсан тохиолдолд шүүхээр шийдвэрлүүлэхтэй холбогдон гарсан бүх зардал;
8. Хувийн ашиг сонирхлоор эмнэлгийн бус орчинд эсвэл ажлын бус цагаар (гэнэтийн өвчин, осол, гэмтлээс амь насанд нь аюултай байдал бий болсон иргэн, төрөх гэж байгаа эхэд эмнэлгийн тусламж үзүүлсэн тохиолдлоос бусад) хийсэн эмнэлгийн тусламж үйлчилгээ;
9. Судалгаа шинжилгээ, дадлага, туршилт хийх, шалгалт өгөх зорилгоор хийсэн эмнэлгийн тусламж үйлчилгээ;
10. Үйлчлүүлэгч эсвэл түүний хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалагч этгээдийн зүгээс “гомдолгүй” гэж баталгаа гаргасны үндсэн дээр хийгдсэн эмнэлгийн тусламж үйлчилгээ мөн түүнээс үүдэлтэй үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжгүй байдал, аливаа сэтгэл санааны хохирол;
11. Эрүүл мэндийн тухай хууль тогтоомж, оношилгоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэх ажлын стандарт, технологи, эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх удирдамжийг мөрдөж ажиллаагүйгээс учирсан хохирол;
12. Үйлчлүүлэгчийн авч ирсэн, эмчилгээ үйлчилгээнд хэрэглэхийг өөрөө хүссэн эм тариа, эмчилгээний бусад материалыг эмчилгээнд хэрэглэсэн;
13. Эмнэлгийн тусламж үзүүлэх үүргээ хүндэтгэх шалтгаангүйгээр биелүүлээгүй тохиолдол;
14. Оношийг санаатайгаар өөрчилсөн, нуун дарагдуулснаас үүдсэн хохирол;
15. Өөрийн үүрэгт ажлыг зөвшөөрөлгүйгээр бусдад шилжүүлсэн;
16. Төрөл бүрийн хүү, торгууль, шийтгэвэр, шийтгэл, захиргааны хариуцлага;
17. Зөвшөөрөлгүй, бүртгэгдээгүй, хугацаа хэтэрсэн, стандартын зохих шаардлага хангаагүй эм тариа, материал, бүх төрлийн багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг хэрэглэснээс үүдэн гарах үр дагавар;
18. Оршуулах зардалд багтаасан шашны зан үйлтэй холбоотой зардлууд;
19. Мэргэжлийн үйл ажиллагааг явуулах эрхгүй байх;
20. Эм хангах нийлүүлэх байгууллагын хариуцлага;
21. Хөдөлмөрийн болон ажлын байрны аюулгүй ажиллагааны зөрчлөөс учирсан хохирол;
22. Нотлогдоогүй хохирол;
23. Дайн, дайн бүхий байдал, зэвсэгт бослого, байлдааны зэвсэг хэрэглэх, үймээн самуун, террорист үйл ажиллагаа, бослого, ажил хаялт, төрийн захиргааны байгууллагын акт шийдвэр, улс төрийн тэмцэлд оролцсон, цөмийн дэлбэрэлт, цацраг идэвхт бодис буюу туяаны хордлого;

24. Даатгуулагч даатгалын зүйлийн талаар болон өөрийн мэдэж байгаа аюул учруулах буюу даатгалын тохиолдол бий болоход нөлөөлж болох ноцтой нөхцөл байдлын талаар худал мэдээлсэн, хуурамч бичиг баримт бүрдүүлсэн нь тогтоогдсон;
25. Гэрээний хугацаа дууссан эсвэл гэрээ дуусгавар болсон;
26. Монгол Улсын нутаг дэвсгэрээс гадна явуулсан мэргэжлийн үйл ажиллагаанаас учирсан хохирол;
27. Хууль болон гэрээнд заасан бусад үндэслэл.